



МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 07 сарын 07 өдөр

Дугаар А/374

Номгон

Г Усны тоо бүртгэлийг зохион байгуулах тухай Г

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.3, Усны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3 дахь заалт, 12 дугаар зүйлийн 12.1.1, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдааны 2022 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн 12/54 дүгээр тогтоолоор батлагдсан "Аймгийн 2023 оны хөгжлийн төлөвлөгөө"-ний 3.1.4 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Усны тоо бүртгэлийг 2023 оны 07 дугаар сарын 06-ны өдрөөс 09 дүгээр сарын 15-ныг хүртэлх хугацаанд зохион байгуулсугай.

2.Усны тоо бүртгэлийг зохион байгуулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай


3.Усны тоо бүртгэлийг зохион байгуулахад шаардагдах 20,000,000 (Хорин сая) төгрөгийг Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг Байгаль орчин, аялал жуулчлалын газар (Э.Ганзориг)-т зөвшөөрсүгэй.

4.Дээрх ажлыг үр дүнтэй зохион байгуулж, мэргэжил арга зүй, удирдлагаар хангаж, тайлан, үр дүнг нэгтгэн 2023 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор аймгийн Засаг даргын Тамгын газрын архив болон холбогдох байгууллагад хүргүүлэх ажлыг зохион байгуулахыг Бөөнцагаан-Орог нуурын сав газрын захиргаа (Б.Ням-очир)-д үүрэг болгосугай.

5.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс (Т.Хишигбаатар)-т даалгасугай.

ДАРГА

Д.МӨНХСАЙХАН



УСНЫ ТОО БҮРТГЭЛИЙГ ЗОХИОН БАЙГУУЛАХ
АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн ахлагч:

Б.Ням-очир Бөөнцагаан - Орог нуурын сав газрын захиргааны дарга

Гишүүд:

Г.Нансалмаа Бөөнцагаан - Орог нуурын сав газрын захиргааны Гадаргын усны
нөөц, судалгаа шинжилгээний асуудал хариуцсан ахлах
мэргэжилтэн

Б.Зүгдоржав Байгаль орчин, аялал жуулчлалын газрын Усны асуудал
хариуцсан мэргэжилтэн

Ш.Бат-очир Бөөнцагаан - Орог нуурын сав газрын захиргааны Нуурын
экосистемийн үнэлгээ, судалгаа шинжилгээний асуудал хариуцсан
мэргэжилтэн

Т.Ариунзаяа Бөөнцагаан - Орог нуурын сав газрын захиргааны Газар зүйн
мэдээлэл, усны мэдээллийн дэд сан хариуцсан мэргэжилтэн

М.Дүүрэн Бөөнцагаан - Орог нуурын сав газрын захиргааны Газрын доорх
усны нөөц, хяналт шинжилгээ хариуцсан мэргэжилтэн

Сумын Засаг дарга, Багийн Засаг дарга, Байгаль орчны хяналтын Улсын байцаагч,
Байгаль хамгаалагч, Ус судлалын харуулын ажиглагч нар

Нарийн бичгийн дарга:

Б.Намуун Аймгийн Засаг даргын Тамгын газрын Байгаль орчин, аялал
жуулчлал, газрын харилцаа, уул уурхайн бодлого хариуцсан
мэргэжилтэн